



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 27

Эрдэнэт

Дүгнэлт өгөх, төлөвлөгөө  
батлах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Онцгой байдлын газраас 2016 онд ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлыг “хангалттай” гэж дүгнэсүгэй

2. Аймгийн хэмжээнд 2017 онд ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлж биелэлтийг 2017 оны 12 дугаар сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг Онцгой байдлын газрын дарга /Г.Ганбаатар /-т үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон дээрх чиглэлээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийн асуудлыг шуурхай шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга Д.Батлутаг даалгасугай.

ДАРГА  П. ПҮРЭВЛХАГВА

